

ХУУЛЬ ЁСНЫГ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ ГЭМТ ХЭРГИЙГ ҮГҮЙСГЭГЧ НӨХЦӨЛ БАЙДАЛ БОЛОХЫН ЭРХ ЗҮЙН МӨН ЧАНАР

Б.Хишигтогтох

ХСИС-ийн, Цагдаагийн сургуулийн, Мөрдөх
ажиллагааны онол тактикийн тэнхимийн ахлах
багш, докторант, цагдаагийн дэд хурандаа

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх үйл явдлын мөн чанарыг тодорхойлохын тулд түүний эрх зүйн шинж, үндсэн ойлголтыг эрүүгийн эрх зүй ба эрх зүйн бусад салбарын хэм хэмжээтэй харьцуулан судлах замаар холбогдох асуудлыг томъёолох шаардлагатай. Тухайлбал, Ю.В.Баулин энэ тухай бичихдээ: “хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал болохын хувьд түүний бодит шинж, хамаарах нөхцөл байдлуудын ерөнхий ойлголтыг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны арга зүйн үүднээс бүхэлд нь авч үзэх хэрэгтэй юм.”¹ гэж асуудлыг цогцолбор байдлаар нь судлахын ач холбогдлыг оновчтой тэмдэглэсэн байна.

Ер нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлууд, тэдгээрийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны системд эзлэх байр суурийг цогцолбороор нь авч үзэх зайлшгүй шаардлагатай бөгөөд ялангуяа түүний эрх зүйн мөн чанар, хэлбэрүүдийг нилээд эх сурвалж байдлаар нь тэгэхлээр эрүүгийн хууль тогтоомжийн хөгжлийн үе шаттай нь холбон авч үзэхээс аргагүй юм. Яагаад гэвэл гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал гэдэг томъёолол нь харьцангуй шинэлэг бөгөөд түүнийг өмнөөс нь “үйл явдлын аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд” гэж томъёолж байсан болно. Энэ талаар дэлгэрүүлэн авч үзье.

Уг асуудлыг Монголын Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны системд нилээд дорвитой, дэлгэрэнгүй судалсан эрдэмтэнийг Г.Совд гэж зүй ёсоор үздэг.² Сүүлийн үед Монгол Улсын гавъяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Жанцан «Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол», (I-р боть, УБ, 2009 он) гэсэн суурь бүтээлдээ уг асуудлыг онол-арга зүй, практикын талаас нь нарийвчлан томъёолж бичсэн болно.

“Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал” гэдэг томъёолол нь ОХУ-ын Эрүүгийн хууль тогтоомжинд 1997 онд анх тусгагдсан бөгөөд хууль тогтоогч уг хуулийн 8-р дугаар бүлгийг ийнхүү томъёолж, эдгээр нөхцөл байдлыг тусгасан байна. Үүнд: 37-р зүйл (Аргагүй хамгаалалт), 38-р зүйл (Гэмт хэрэг үйлдэх үед нь түүнийг гэм хор учруулах замаар таслан зогсоох), 39-р зүйл (Гарцаагүй байдал), 40-р зүйл (Биеийн хүчний ба сэтгэцийн албадлага), 41-р зүйл (Үндэслэл бүхий эрсдэл), 42-р зүйл (Тушаал, шийдвэр, даалгавар биелүүлэх) гэсэн 6 зүйлийг багтаажээ. Энэ нь судлаач эрх зүйчдийн, нэн ялангуяа эрүүгийн эрх зүйчдийн дунд эрдэм шинжилгээний чанартай урт хугацааны маргаан – хэлэлцүүлэг үүсгэсэн бөгөөд уг асуудлыг Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд одоо хэр нэг мөр шийдвэрлээгүй байна.

Энэ нь Зөвлөлтийн эрин буюу социализмын эрх зүйн үетэй салшгүй холбоотой бөгөөд тухайн үед гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал гэдэгт аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлыг хамруулж байсан боловч түүнээс бүр өмнөх үеийн судлаачид уг асуудлыг нилээд өргөн хүрээнд авч үзэж байсныг тэмдэглэхгүй байх аргагүй. Тухайлбал, 1948 онд В.И.Чихвадзе³, А.А.Герцензон⁴ нар цэргийн гэмт хэргийн бүрэлдэхүүнд тэр үедээ харьцангуй шинэлэг томъёоллыг, онцолбол цэргийн үүрэг биелүүлэх явцад үйлдсэн гэмт хэргийг аюулыг үгүйсгэгч нөхцөл байдалд хамааруулж байсан бол нилээд хожим үед И.И.Слуцкий⁵ “Үгүйсгэх нөхцөл байдлуудыг:

1. Нийгэмд ашигтай, хууль ёсны болох шинж нь илт тодорхой нөхцөл байдлууд (Аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, гэмт хэрэгтнийг баривчлах, тушаал биелүүлэх, албаны ба мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэх гэх мэт)
2. Сайн дураараа татгалзах, хохирогчийн зөвшөөрөл, үл ялих хэрэг зөрчил зэрэг үйлдэлтэй холбоотой аюулыг үгүйсгэх нөхцөл байдал
3. Биеийн хүчний албадлага ба давагдашгүй хүчинд автах нөхцөл байдал гэж 3 бүлэг болгон хувааж үзэж байсан бол А.М.Санталов⁶ аюулыг үгүйсгэх нөхцөл байдалд: аргагүй хамгаалалт, гэмт хэрэгтнийг баривчлах, гарцаагүй байдал, тушаал биелүүлэх,

¹ Баулин.Ю.В. Обстоятельства, исключаяющие преступность деяние. – Харьков, 1991. 14-р тал

² Г.Совд. БНМАУ-ын эрүүгийн эрх зүйн курс. УБ.1974.269-284-р тал

³ Чихвадзе.В.И. Советское военно – уголовное право. М.1948. 8-р тал

⁴ Герцензон.А.А. Уголовное право. Часть общая. М.1948. 263-268-р тал

⁵ Слуцкий.И.И. Обстоятельства, исключаяющие уголовную ответственность. 1956. 11-12-р тал

⁶ Санталов.А.М. Курс советского уголовного права. Часть общая. 1968. 465-533 тал

хохилогчийн зөвшөөрлөөр мэргэжлийн үүргээ гүйцэтгэх, өөртөө буй эрх ба үүргээ хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн эрсдэл зэргийг хамааруулан авч үзсэн ба А.А.Пионтковский⁷ ч гэсэн дээрхтэй бараг ижил ангиллыг дэвшүүлэн гаргажээ.

Үүнээс үзвэл тухайн үеийн хууль тогтоомжийн заалт ба уг асуудалтай холбоотой эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны томъёолол нь өөр хоорондоо нилээд зөрүүтэй байсан нь уг асуудалд онол – арга зүйн судалгаа боловсруулалт дутмаг байсантай холбоотой бөгөөд энэ тухай С.Келина⁸ тэмдэглэхдээ: «шүүхийн практик нь эрүүгийн эрх зүйн онол – арга зүйн үндэслэлийг тэр болгон хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг боловсруулахдаа харгалздаггүй байв» гэснийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.

Яагаад гэвэл одоо ч гэсэн шүүхийн практик ба эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны судалгаа – арга зүй хоёр зөрчилдөж байгаа тодорхой баримтууд байсаар байна. Тухайлбал, тодорхой эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд тухайн хүнийг (гэмт хэрэгтнийг) хууль ёсны эрхээ хэрэгжүүлсэн үндэслэлээр үйлдсэн хэргийг нь хэрэгсэхгүй болгосоор байгаа нь үүнийг батална.

Гэвч 1991 онд батлан дагаж мөрдсөн “ЗХУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн үндэс”-д аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний хүрээг нилээд нэмэгдүүлсэний дээр уг асуудлаар олон судлаач – эрдэмтэн тодорхой бүтээл туурвисан боловч бодит практик ба шинжлэх ухааны арга зүй хоёр зөрчилтэй хэвээр байсан бөгөөд ялангуяа судлаачид аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын талаарх хуулийн заалтыг (Эрүүгийн эрх зүйн) улам дэлгэрэнгүй болгох талаар бодитой саналууд дэвшүүлсэн байна. Тухайлбал, Н.Г.Кадников⁹ эрүүгийн хууль тогтоомжид хохирогчийн зөвшөөрлөөр өөрт буй эрх ба мэргэжлийн үүргээ хэрэгжүүлсэнийг, В.В.Орехов¹⁰ хохирогчийн зөвшөөрлөөр тусгай даалгавар хэрэгжүүлсэн зэргийг аюулыг үгүйсгэх нөхцөл байдалд хамруулсан юм.

Энэ нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан Бүгд Найрамдах Улсуудын Эрүүгийн хуулинд мөн адил байдлаар тусгалаа олсон. Тухайлбал, Украин улсын Эрүүгийн хуулийн 43-р зүйл¹¹, Казакстан улсын Эрүүгийн хуулийн 34-р зүйл¹², Беларусь улсын Эрүүгийн хуулийн 38-р зүйл¹³-үүдэд гэмт бүлэглэл буюу гэмт байгууллагын зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх, тусгай даалгавар хэрэгжүүлэх, эрэн сурвалжлах, тусгай үүрэг гүйцэтгэх, гэмт хэргийн бүлэглэлд тусгай үүрэг гүйцэтгэхээр нэвтрэх явцад бусдад гэм хор учруулах зэргийг аюулыг үгүйсгэх нөхцөл байдалд хамруулахаар заасан байна. Эдгээр нь бүгд хууль ёсны үүргээ хэрэгжүүлэх үндэслэлээр гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамааруулсан байна.

Гэвч эдгээр нөхцөл байдал нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаан дахь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлэхэд учир дутагдалтай бөгөөд үүнийг олон судлаач өөрсдийн ном зохиолдоо тайлбарлан бичсэн байдаг. Тэгэхдээ хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны эрх зүйн мөн чанарыг бүрэн илэрхийлэхийн тулд чухамхүү гэмт хэргийг үгүйсгэж байгаа тэрхүү нөхцөл байдлынх нь мөн чанарыг илүү дэлгэрэнгүй судлан тодорхойлох шаардлагатай дээр үүнийг зөвхөн эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд авч үзэх боломжгүй тул Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны нарийвчилсан судалгаагаар асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Ингэснээр эрүүгийн хууль тогтоомжийн үзэл сурталжсан болон тухайн цаг үеийн хууль тогтоогчийн дарамтнаас ангижрах боломжтой болох тул эрүүгийн эрх зүйн нэрт эрдэмтдийн суурь бүтээлийг зайлшгүй судлах, ишлэл авах шаардлагатай юм. Тухайлбал, А.Н.Трайнкин¹⁴ 1929 онд хэвлүүлсэн эрүүгийн эрх зүйн алдарт бүтээлдээ аргагүй хамгаалалт ба гарцаагүй байдлын мөн чанарыг томъёолохдоо “энэхүү тохиолдолд тухайн этгээдийн хийж байгаа үйл ажиллагаа, нэн ялангуяа илрэх хэлбэр нь нийгэмд аюултай үйлдлийн бодит шинжүүдийг илэрхийлж байдаг боловч мөн чанарын хувьд нийгэмд аюултай бус харин өөрийнхөө болон бусдын эрх ашгийг хамгаалж байдаг тул эцсийн дүндээ эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй байдаг.” гэжээ.

⁷ Пионтковский.А.А, Курс советского уголовного права. Преступление М.1970, 346-392-р тал

⁸ Келина.С, Обстоятельства, исключаяющие преступность деяния: понятие и виды. Уголовное право. 1999. №3, 6-р тал

⁹ Кадников.Н.Г. , Обстоятельства, исключаяющие деяния. М.1998. 39-45-р тал

¹⁰ Орехов.В.В, Необходимое оборона и иные обстоятельства, исключаяющие преступность деяния. 160-165-р тал. Модельный Уголовный кодекс: Рекомендательный законодательный акт для стран СНГ. Информационный бюллетень. 1996. №10.

¹¹ Украина. Законы. Уголовный кодекс Украины. Официальный текст. 2001. 21-р тал

¹² Республика Казакстан. Уголовный кодекс Республики Казакстан: Официальный текст. 2001. 15-р тал

¹³ Республика Беларусь. Уголовный кодекс Республики Беларусь: Официальный текст. 2001. 20-р тал

¹⁴ Трайкин.А.Н. Уголовное право. Общая часть. М.1929, 468-р тал

Асуудлын мөн чанарт ингэж хандаж байснаар тухайн болсон бодит үйл ажиллагааны мөн чанарыг нарийвчлан тодорхойлж чадвал аюулыг үгүйсгэх нөхцөл байдалд тооцож болох юм гэдэг чухамхүү эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны арга зүйн суурь – үндсийг тавьж чадсан билээ.

Ингэснээр шүүхийн ба мөрдөн байцаалтын үйл ажиллагааны практикт аюулыг үгүйсгэх нөхцөл байдалд үнэхээр социологи арга зүйн үүднээс хандах боломжтой болсон бөгөөд 1952 онд хэвлэгдсэн эрүүгийн эрх зүйн сурах бичиг¹⁵-г энэ тухай бичихдээ “аргагүй хамгаалалтыг аливаа хууль бус үйл явдлыг хайцаалах бамбай болгож болохгүй бөгөөд хэрэв тийм байдалд хүрвэл аливаа хууль зөрчсөн балмад хүчирхийллийг ч гэсэн аргагүй хамгаалалтад тооцох байдалд хүргэж болох юм гэдгийг онцгой анхаарах хэрэгтэй” гэжээ. Энэ нь аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын мөн чанарыг таньж мэдэхэд илүү шинжлэх ухаанч, үнэхээр социологи (язгуур амин ашиг) арга зүйн үүднээс хандахад хүргэсэн.

Дээрх эрдэмтдийн үзэл бодлыг дэмжиж А.А.Пионтковский¹⁶ бичихдээ: “тодорхой тохиолдол – тохироонд болсон тухайн бодит үйл явдал нь илрэх шинж тэмдэгээрээ гэмт хэрэгтэй төсөөтэй байж болох боловч жинхэнэ мөн чанарыг нь зөв таньж, тодорхойлж чадвал тэр нь нийгэмд аюултай биш харин нийгэмд ашигтай, социалист эрх зүйн хэв журмыг болон иргэдийн эрх ашгийг хамгаалсан үйл явдал байж болох талтай” гэжээ. Ийнхүү эрүүгийн эрх зүйд социологи арга нэвтэрч төлөвшиж эхэлсэн билээ.

Аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын зөвхөн нийгэмд ашигтай байж болох шинжийг бодитой тогтоох төдийгүй уг үйл ажиллагаа нь хууль – эрх зүйн үндэслэлтэй болохыг илүү оновчтой, нарийвчлан тогтоох шаардлагатай гэдгийг олон судлаач тэмдэглэн бичсэн байдаг. Ялангуяа И.И.Слущкий¹⁷ бичихдээ: асуудлыг ийнхүү өргөн хүрээнд авч үзсэнээр а) аюулыг үгүйсгэгч нөхцөл байдал, б) ял шийтгэлийг буюу эрүүгийн хариуцлагыг үгүйсгэгч нөхцөл байдал хоёр нь хэдүйбээр агуулгын хувьд төсөөтэй боловч эрх зүйн мөн чанарын хувьд харьцангуй өөр юм гэдгийг онцгой анхаарах хэрэгтэй гэж тэмдэглэсэн байдаг.

Чухамхүү аюулыг үгүйсгэгч нөхцөл байдлуудын эрх зүйн мөн чанарыг бодитой тодорхойлох талаар эрүүгийн хууль тогтоомжинд нилээд тогтвортой, тодорхой чиглэл – байр суурь бүрэлдэн буй болсон боловч судлаач – эрдэмтдийн дунд одоо хэр нэгдмэл үзэл бодол байхгүй байна. Хэдүйбээр аюулыг үгүйсгэх буюу өнөөгийн томъёоллоор гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг үндсэн 6 төрөлд хувааж буй боловч судалгаа – арга зүйн эргэлзээ төрүүлсэн хэвээр байна.

Тухайлбал С.Ф.Миллюков¹⁸ үзэхдээ тухайн нөхцөл байдлын гэмт хэргийг үгүйсгэх шинж нь гол биш чухамхүү нийгмийн аюулыг үгүйсгэж буй бодит шинж нь онцгой чухал гэжээ. Ингэснээр гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хандах эрх зүйн 3 өөр чиглэл байна гэж үзэж болох юм. Тухайлбал А.П.Дмитренко¹⁹ үзэхдээ а) нийгмийн (социаль), б) хэм хэмжээт, в) хэм хэмжээг – социаль хандлагаар тодорхойлох хэрэгтэй гэжээ. Энэ асуудалд ул суурьтай хандсанаар дээр дурьдсан 3 хандлагын аль нь аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын мөн чанарыг тал бүрээс нь авч үзэж буй, ялангуяа хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл явдал нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамаарах эсэхийг судлан тогтооход арга зүй – практикийн ач холбогдолтой байж болох талтай.

Ялангуяа гэмт хэрэг ба гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын жинхэнэ язгуур мөн чанарыг ялган тодорхойлох социал хандлагыг таньж мэдэхэд ач холбогдолтой юм.

Дээрх судлаачид тухайн бодит нөхцөл байдлын чухамхүү нийгмийн аюулыг үгүйсгэж байгаа тэрхүү гол шинжийг нь зөв тогтоосноор гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг тодорхойлох эрх зүйн мөн чанар гарч ирнэ гэж үзэж байна. Тухайлбал С.Ф.Миллюков²⁰ бичихдээ: “аргагүй хамгаалалтын ба гарцаагүй байдлын үед хийж байгаа үйл ажиллагааны зөвхөн гадаад буюу хэлбэрийнх нь биш харин чухамхүү үнэн бодит шинжийг нь зөв тогтоож чадвал үнэхээр эрүүгийн хуулийн тусгай ангид тусгаж болохуйц шинж тэмдэгтэй болж чадна” гэжээ.

Хэрэв тухайн нөхцөл байдлын бодит шинжийг үнэхээр хууль зүйн үндэстэйгээр тогтоож чадвал бусдыг санаатай алах, бусдын биед янз бүрийн гэмтэл учруулсан гэмт хэргийн ч гэсэн нийгмийн буюу гэмт хэргийн аюулынх нь шинжийг үгүйсгэж болох талтай. Энэ саналыг Зөвлөлтийн эрүүгийн эрх зүйн курс²¹ сурах бичгийн зохиогчид дэмжсэн.

¹⁵ Советское уголовное право. Часть общая. Ред.В.Н.Чихвадзе. М1952. 249-р тал

¹⁶ Пионтковский.А.А. Учение о преступлений по советскому уголовному праву. М.1961, 410-414-р тал

¹⁷ Слущкий.И.И. Обстоятельства, исключающие уголовную ответственность. Л.1956, 11-12-р тал

¹⁸ Миллюков.С.Ф. Обстоятельства, исключающие общественную опасность деяния. 1998, 2-р тал

¹⁹ Дмитренко.А.П. Причинение вреда при задержания лица, совершившего преступление. Ставрополь, 2002. 10-р тал

²⁰ Миллюков.С.Ф. Обстоятельство, исключающие общественную опасность деяния. 1998, 5-р тал

²¹ Курс советского уголовного права. Общая часть. 1968, 160-р тал

Гэвч А.П.Дмитренко²² үзэхдээ: энэ хандлага нь уг асуудлын социал ба хууль цаазын хэлбэрийн агуулгын ялгааг бүрэн дүүрэн тодорхойлж чадахгүй гэсэн юм. Яагаад гэвэл асуудалд ийнхүү цогцолбор байдлаар хандаж чадахгүйн улмаас гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын мөн чанарыг бүрэн дүүрэн илэрхийлэхгүй бөгөөд эрүүгийн хууль тогтоомжид заасан шинжийг тогтоох хүрээнд асуудлыг шийдвэрлэх л хэмжээнд хүрэх ба өөр хоорондоо харилцан хамааралтай бодит нөхцөл байдлуудын социал-эрх зүйн шинжийг цогцолбороор нь тогтоох боломжгүй” гэжээ.

Ийнхүү гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын нийгмийн хор аюулыг ямар шалгуураар тодорхойлон тогтоох вэ гэдэг нь маргаан дагуулсаар байна.

Одоо гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын хууль цаазын мөн чанарыг тодорхойлоход баримтлаж буй хэм хэмжээт хандлагын талаар авч үзье. Энэхүү үзэл бодлыг үндэслэгч нь М.М.Исаев²³ юм. Тэрээр бичихдээ: “тушаал биелүүлж байгаа үйл ажиллагаа нь хэдүйбээр гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдалд хамаарч болох талтай боловч тухайн тушаал нь өөрийн мөн чанарын хувьд нийгэмд аюултай байдаг тул уг үйл явдлын нийгмийн хор аюулыг заавал тогтоох ёстой” гэсэн бол Ю.И.Ляпунов үзэхдээ: “тухайн үйлдлийн эрх зүйн эсрэг байгаа бодит мөн чанарыг нь хиймлээр хэт дөвийлгөж хэрхэвч болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй”²⁴ гэжээ.

Харин В.М.Галкин дээрх үзэл бодлоос нилээд өөр байдлаар асуудалд хандсан байна. Тухайлбал “нийгмийн хор аюул ба эрх зүйн эсрэг мөн чанар хоёрыг тэр болгон нэг түвшинд авч үзэхэд учир дутагдалтай байдаг. Яагаад гэвэл тухайн бодсон үйл явдлын эрх зүйн эсрэг мөн чанар нь биш харин чухамхүү нийгмийн хор аюул нь илүү бодитой байдаг бөгөөд тухайн хууль буюу эрх зүйн алдааны улмаас уг ажиллагаа илэрсэн тохиолдолд чухамхүү эрх зүйн эсрэг мөн чанар нь илүү илрэх талтай байдаг”²⁵ гэжээ.

Үүнийг анхаарч үзүүштэй бөгөөд уг болсон үйл явдал нь чухамхүү хууль-эрх зүйн актын алдааны улмаас болж гарсан тохиолдолд үнэхээр эрх зүйн эсрэг мөн чанар нь илрэх бөгөөд уг үйл явдлын социал агуулга нь хууль тогтоомжийн хэлбэртэй зөрчилдөхөд хүргэх бөгөөд тэгснээрээ бодит үйл явдал хууль цааз хоёр амьдрал-практикт зөрчилдөхөд хүргэдэг гэдгийг тайлбарлахыг оролдсон байна. Тодруулбал эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлсон нөхцөл-шалгуур нь гэмт хэрэг-зөрчлийн бодит байдалтай тэр болгон нийцэхгүй байж болох талтай гэдгийг тайлбарлахыг оролдсоноор хэм хэмжээт хандлагын талаар судлаачдын дунд нилээд маргаантай асуудлыг дэвшүүлжээ. Ялангуяа Ю.В.Баулин үзэхдээ “үйл явдлын нийгмийн хор аюул ба эрүүгийн эрх зүйн эсрэг мөн чанар хоёрын агуулга, хэлбэр нь тэр болгон өөр хоорондоо зохицохгүй байж болох талтай.

Учир нь болсон үйл явдал нь гол төлөв материаллаг буюу бодит шинжтэй байдаг тул уг үйл явдлын нийгэм-улс төрийн агуулгыг илэрхийлж байдаг бол эрүүгийн эрх зүйн эсрэг мөн чанар нь түүний хууль цаазын хэлбэрийг илэрхийлдэг”²⁶ гэж үзсэн нь нэг талаар үндэстэй санагдана. Учир нь эрүүгийн хууль тогтоомжид болсон (болох) үйл явдлын агуулгыг нь тэр болгон бүрэн дүүрэн тодорхойлох боломжгүй байдаг тул юуны өмнө хэм хэмжээт мөн чанарыг нь тодорхойлоход хүрдэг гэдгийг өнөөгийн хууль тогтоомжийн практик харуулж байна. Ер нь эцсийн эцэст болсон үйл явдлын социал агуулга нь чухамхүү хууль цаазын хэлбэртэй болсноороо эрх зүйн ач холбогдлоо олдог гэж²⁷ Ю.М.Ляпунов оновчтой тэмдэглэснийг дэмжиж байна.

Дээрхээс үзвэл болсон үйл явдлын нийгмийн хор аюул ба эрх зүйн эсрэг мөн чанар хоёр нь өөр хоорондоо диалектик хэлхээ хамааралтай зүйл болох нь тодорхой тул аль аль нь тодруулбал хэм хэмжээт шинж ба бодит агуулга нь болсон үйл явдлын агуулгыг илэрхийлж байгаа тул хэлбэр агуулга нь зөрчилдөж буй тохиолдолд уг болсон үйл явдлыг (гэмт хэргийг) үгүйсгэхэд хүргэх нь тодорхой. Үүнийг Ю.В.Баулин нарийвчлан судлаж ийм тохиолдлын байж болох 3 төрлийг гаргаж ирсэн байна. Үүнд **Нэгдүгээрт:** Үйл явдлын агуулга нь тухайн гэмт хэргийн шинжтэй адилхан байх боловч хууль цаазын хэлбэр нь тохирохгүй байх тохиолдол гардаг. Энэ нь ялангуяа эрх зүй-хуулийн алдаа(цоорхой)–тай холбоотой байдаг. Энэ тохиолдолд уг болсон үйл явдлын эрүүгийн эрх зүйн эсрэг мөн чанар нь давамгайлдаг.

Өөрөөр хэлбэл хуулиар хүлээн зөвшөөрсөн боловч мөн чанарын хувьд эрх зүйн эсрэг үйл явдал байдаг. **Хоёрдугаарт:** Амьдрал-практикт гардаг (гарч болох) үл ялих хэрэг зөрчил нь нэн ялангуяа илрэх хэлбэр шинжээрээ гэмт хэрэгтэй төсөөтэй мэт боловч түүнийг холбогдох эрх зүйн

²² Дмитренко А.П. мөн бүтээлийн 20-р тал

²³ Исаев.М.М. Основные начала уголовного законодательства СССР и союзных республик, 1927. 49-р тал

²⁴ Ляпунов Ю.М.Общественная опасность, деяния как универсальная категория советского уголовного права. М.1989 63-р тал

²⁵ Галкин В.М. Проблемы полноты уголовно-правового регулирования. Проблемы совершенствования советского законодательства. М.1987.№37. 192-р тал

²⁶ Баулин. Ю.В. Обстоятельства, исключаящие преступность деяния, Харьков 1991.

²⁷ Ляпунов.Ю.М. Общественная опасность, деяния как универсальная категория советского уголовного права. М.1989. 63-р тал

актанд хэрэг зөрчилд тооцоогүй тохиолдол байдаг. Энэ нь мөн чанарын хувьд аюулыг үгүйсгэх нөхцөл байдалд хамаарч болох талтай. **Гуравдугаарт:** Зарим хэрэг–зөрчил зөвхөн гадаад шинж хэлбэрээрээ гэмт хэрэгтэй адилхан байх боловч жинхэнэ дотоод мөн чанар-нийгэм улс төрийн агуулгаараа өөр буюу эрс тэс зөрчилтэй байх тохиолдол байдаг. Үүний хамгийн сонгодог жишээ нь аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэх зэрэг үйл явдал юм гэж үзжээ.

Иймд нийгмийн хор аюулыг үгүйсгэх болон гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал хоёрын агуулга, хэлбэр, шинж тэмдгийг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны арга зүйн үүднээс нарийвчлан судлах замаар бодитой зааглан тогтоож түүнийг эрүүгийн хууль тогтоомжид тусган оруулах нь судлаач-эрдэмтдийн нэн даруй тулгарч буй зорилт болж байна.

Энэ тухай С.Г.Келина, В.Н.Кудрявцев, П.А. Фефелов нар бичихдээ судлаж буй асуудлын мөн чанарыг нарийвчлан тогтоон тодорхойлох замаар гэмт үйл явдал ба гэмт бус үйл явдлын нарийн заагыг бодитой тогтоох нь зайлшгүй бөгөөд төр-засаг захиргааны байгууллага, бүх албан тушаалтан, олон нийтийн байгууллага, иргэн нэг бүрийн үйл ажиллагаандаа зөвхөн хуулийг баримталж түүнийг үндэслэн гарсан эрх зүйн бүх баримт бичгийг ягштал сахиж биелүүлэх нь өнөөгийн эрх зүйт төрийн өөрийнх нь мөн чанараас урган гарч байгаа нийгэм-олон нийтийн бодит шаардлага болж байна²⁸ гэжээ.

Үнэхээр ч аливаа эрх зүйн шинжлэх ухааны ерөнхий, төрлийн, хэсгийн судлагдахуун ойлголтын ялгаа заагыг нарийвчлан тодорхойлсноор тухайн холбогдох хууль-эрх зүйн актыг боловсруулах, батлан гаргах жинхэнэ шинжлэх ухааны эх сурвалж, арга зүйн үндэс болдог нь нэгэнтээ тогтоогдсон зүйл билээ.

Ер нь амьдрал-практикт болж байгаа (болох) үйлдлийг гэмт хэрэгжүүлэх (одоо манай практикт хэрэгжүүлэх гэдэг тун ч сонсголонгүй үгээр томъёолж байгаа, энэ тухай жич өгүүлнэ) буюу гэмт хэрэггүйжүүлэх (декриминализаци) үйл явцыг нарийн шинжлэх ухааны арга зүйн үндэслэлгүйгээр шийдвэрлэх ямар ч боломжгүй юм.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны ном бүтээлд энэхүү асуудлыг 1990-ээд оны эхэн үе хүртэл бараг дурьддаггүй шахам байсан бөгөөд ялангуяа гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын талаар энэ тухай дагнасан ном, сурах бичиг (ялангуяа Монголд) огтхон ч байсангүй гэж үзэж болох талтай. Харин ОХУ-ын хувьд 1996 оны шинэ эрүүгийн хууль батлагдан гарснаар энэ чиглэлийн судалгаа-шинжилгээний ажил нилээд идэвхжиж эхэлсэн боловч эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны нэгдмэл арга зүй одоо хэр төлөвшөөгүй, холбогдох асуудлуудын талаар судлаач-эрдэмтдийн социал-онол зөрчилдөөнтэй хэвээр байгаа боловч 2000 оны эхээр ОХУ-д энэ чиглэлийн олон судалгаа-бүтээл хэвлэгдэж гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын тухай зарим эрдэмтэд нилээд дорвитой, суурь бүтээлүүдийг гаргаад байна²⁹. Тухайлбал С.Г.Келина аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын талаар бичихдээ: тухайн этгээдийн хийсэн бодит үйл ажиллагаа нь нийгэм, төр-засаг, бие хүний эсрэг гэм хор учруулсан боловч уг үйлдэл нь тэр нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хийсэн байвал гэм буруу ба эрх зүйн эсрэг мөн чанар нь үгүйсгэгддэг тул гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцогдоно³⁰ гэжээ.

Хэдүйбээр энэ тодорхойлолт нь тухайн болсон үйл явдлын социал(нийгэм)-эрх зүйн агуулгыг тодорхойлох талаар нэгдмэл шалгуурыг тогтооход эргэлзээтэй боловч анхны чиглэлийг гаргаж өгснөөрөө ач холбогдолтой мэт санагдана.

Энэ тодорхойлолт нь хэдүйбээр аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын агуулгыг илэрхийлэх үндэслэл болж болох талтай боловч (жишээлбэл аргагүй хамгаалалт нь ямагт нийгэмд ашигтай үйл явдал байдаг нь тодорхой) уг үйлдлийн (аргагүй хамгаалалтын) эрх зүйн эсрэг мөн чанарыг нь тэр болгон бодитой тодорхойлоход учир дутагдалтай юм.

Яагаад гэвэл аргагүй хамгаалалт нь бодит мөн чанарын хувьд ямагт хууль-эрх зүйн эсрэг мөн чанартай үйлдэл тул чухамхүү тэр шинжийг нь нарийвчлан тогтоох шаардлагатай. Энэ тухай Р.Р. Галиакбаров³¹ нилээд сонирхолтой дүгнэлт-үндэслэл гаргаж ирсэн байдаг. Тэрээр бичихдээ аргагүй хамгаалалт нь хэдүйбээр бусдад хор хохирол учруулдаг ч гэсэн тэр ямагт тухайн хүний (хамгаалалт хийж буй) ухамсартай, итгэл зоригын дагуу хийсэн үйлдэл байдаг боловч мөн чанарын хувьд ямагт бодит эрх ашгийг хамгаалсан, нийгэмд ашигтай үйл ажиллагаа тул эрүүгийн хууль тогтоомжид заасны дагуу түүнийг аюулыг үгүйсгэгч нөхцөл байдалд тооцдог гэжээ.

Гэвч энэ тодорхойлолт нь нилээд учир дутагдалтай. Тухайлбал чухам ямар эрх ашигт онцолбол эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлсон тэгэхлээр эрүүгийн хуулиар хамгаалсан

²⁸ Келина.С.Г. Принципы советского уголовного права./С.Г.Келина, В.Н.Кудрявцев./ М.1968. 83-р тал
Фефелов.П.А. Понятие и система принципов советского уголовного права. Свердловск. 1970. 94-р тал

²⁹ Баулин.Ю.В. Обстоятельство, исключаяющие преступность деяния. Харьков. 1991.

Курс советского уголовного права. Общая часть. М.2001

³⁰ Курс советского уголовного права. Общая часть./ред.В.Н.Кудрявцев, А.В.Наумов. М.2001. 419-р тал

³¹ Уголовное право России. Общая часть./ред Л.Л.Кругликов/ М.1999, 272-р тал

эрх ашигт хохирол учруулдаг тэрхүү үндсэн-шинж тэмдгийг тодорхой харуулж чадсангүй гэж үзэх талтай юм. Учир нь тухайн бодит явдлын чухамхүү социал-хууль цаазын мөн чанарт хамаарах нөхцөл байдлуудыг нь судлах замаар буюу зөвхөн нийгэмд ашигтай шинжийг үндэслэл болгохгүйгээр тухайн асуудалд арга зүйн үүднээс иж бүрэн хандах шаардлагатай гэж үзэж байна.

Чухам энэ дэвшүүлж буй үндэслэлийг нилээд дөхүү судлан тодорхойлсон нь А.П.Дмитренко юм. Тэрээр гэм хорыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг тодорхойлохдоо энэхүү үйлдэл нь (үгүйсгэх нөхцөл байдал) хэрэг хариуцах чадвартай, эрүүгийн хуулинд заасан насанд хүрсэн, тодорхой хувь хүний үйлдсэн үйлдэл байдаг боловч түүний (үйлдлийн) зорилго нь нийгэмд ашигтай байдаг тул хэдүйбээр уг үйл ажиллагаа нь эрүүгийн хууль тогтоомжоор хамгаалсан бодит харилцаанд хохирол учруудаг боловч уг үйл ажиллагааны чухамхүү эрүүгийн хууль тогтоомжид урьдчилан заасан үндэслэл, эрх зүйн хэр хэмжээг нь нарийвчлан тогтоосон нөхцөлд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцож болох юм³² гэжээ. Энэ тодорхойлолт нь дээр дурьдсан учир дутагдалтай үндэслэлүүдийн ялангуяа хууль-эрх зүйн (эрүүгийн эрх зүйн) бодит шинжүүдийг нь харгалзан үзсэнээрээ нилээн давуу талтай юм.

Бидний үзэж байгаагаар гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлууд нь объектив ба субъектив шинж тэмдгүүдтэй байдаг бөгөөд объектив шинжүүдэд дараахь бодит үндэслэлүүдийг хамааруулж болох талтай мэт санагдана. Үүнд:

1. Уг үндэслэлүүдийг эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр урьдчилан тодорхойлсон байх.
2. Тухайн үйлдэл нь эрүүгийн хуулиар хамгаалсан нийгмийн харилцаанд хохирол учруулсан байх.
3. Эрүүгийн хуулинд бодитой зааж, тодорхойлж өгсөн үндэслэл эрх зүйн хэм хэмжээтэй байх.
4. Уг үйлдэл нь эрүүгийн хуулиар хамгаалсан харилцаанд хохирол учруулсан боловч агуулга-мөн чанарын хувьд нийгэмд ашигтай байх эдгээр болно.

Субъектив шинжүүдэд:

1. Хэрэг хариуцах чадвартай,
2. Эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн,
3. Уг үйлдлийн эцсийн зорилго нь нийгэмд ашигтай байх зэрэг болно.

Харин дээр дурьдсан шинж тэмдгүүдийг зөвхөн эрүүгийн хууль тогтоомжийн хэм хэмжээгээр тодорхойлох тухайд нилээд маргаантай байна. Тухайлбал иргэний буюу захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалсан нийгмийн харилцаанд хор хохирол учруулсан үйлдэл нь дурьдсан эрх зүйн салбарын эсрэг мөн чанартай тул эрүүгийн эрх зүйн шинж тэмдгээр тодорхойлогдохгүй гэж зарим судлаачид үздэг боловч энэ нь бидний үзэж байгаагаар нилээд эргэлзээтэй юм.

Яагаад гэвэл 1960-аад оны эхэн үеэс аюулыг үгүйсгэх нөхцөл байдалд зөвхөн 2 нөхцөл байдлыг (аргагүй хамгаалалт ба гарцаагүй байдал) хамааруулж байсан хэдий боловч шүүх, мөрдөн байцаалтын практикт бусад бодитой нөхцөл байдлуудыг нь тэр бүр үгүйсгээгүй байдаг. Энэ тухай Ю.В.Баулин бичихдээ: Эрүүгийн эрх зүйгээс бусад салбарын хууль тогтоомжоор хамгаалагдсан харилцаануудад хор хохирол учруулсан бодит үйлдлүүд нь илрэх хэлбэр, шинж тэмдгээрээ хэрэг-зөрчилтэй (гэмт хэрэгтэй) төсөөтэй, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байдаг боловч нийгэмд ашигтай мөн чанар зорилгын хувьд аюулыг үгүйсгэх нөхцөл байдалд тооцогддог байв³³ гэжээ.

Гэвч тухайн үеийн эрүүгийн эрх зүйн хууль тогтоомж нь гагцхүү эрүүгийн хуулиар хамгаалсан нийгмийн харилцаанд гэм хор учруулсан үйлдлийг зохицуулдаг байсан тул өнөөгийн цаг үед асуудлыг ингэж тайлбарлах нь зохисгүй юм. Иймд ямар эрх зүйн салбар хууль тогтоомжоор асуудлыг зохицуулах вэ гэдэг нь эрүүгийн эрх зүйн судлаач-эрдэмтдийн анхаарлыг зүй ёсоор татсан хэвээр байна. Тухайлбал В.И.Ткаченко үзэхдээ бусад салбар эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалдаг харилцаанд хор хохирол учруулсан үйлдлийг эрүүгийн хууль тогтоомжийн хэм хэмжээгээр зохицуулах бус харин ч зөрчилдөхөд хүргэж болох тул хэрэг-зөрчлийг зохицуулах эх сурвалж нь эрүүгийн хууль тогтоомжид заасан үндэслүүд байвал зохилтой юм³⁴ гэжээ.

Энэ санааг бид дэмжиж буй бөгөөд хэрэг-зөрчлийг нэн ялангуяа гэмт хэргийг зөвхөн эрүүгийн хууль тогтоомжийн хэм хэмжээгээр зохицуулах нь нэн тодорхой тул гэмт үйлдэл ба гэмт бус үйлдлийн зааг, ялгааг улам нарийвчлан тогтоох улмаар түүнийг хуульчлах шаардлага нэмэгдсээр байна.

³² Дмитренко А.П. Причинение вреда при задержаний лица, совершившего преступление./Ставрополь. 2002, 42-р тал

³³ Баулин. Ю. В. Обстоятельства, исключющие преступность деяния. Харьков, 1991, 41-р тал

³⁴ Ткаченко.В.И. Принуждение к повиновению и выполнению правовой обязанности советско юстиция.1990.№3. 28-р тал

Иймд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг зөвхөн эрүүгийн хуулинд тодорхойлон заах хэрэгтэй бөгөөд энэ нь эцсийн дүндээ үндсэн хууль болон хууль ёсны зарчмаас урган гарч байгаа бодит шаардлага тул гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг гагцхүү эрүүгийн хууль тогтоомжийг үндэслэж зохицуулах хэрэгтэй байна.